



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 01394

Улаанбаатар хот

「 Чингэлтэй дүүргийн 61 дүгээр сургуулийн  
барилгыг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 111 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/935 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 02-07-117/37 дугаар актаар ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороонд байрлах 3,289,481.66 /гурван сая хоёр зуун наян есөн мянга дөрвөн зуун наян нэгэн төгрөг жаран зургаан мөнгө/ төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилгыг актлан, данс бүртгэлээсээ хасч, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн 61 дүгээр сургууль /А.Мөнхчимэг/-д зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 1,500,000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгийн хөрөнгийг борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад даалгасугай

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш ҮНЭНБАТ

115050000955

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын  
2020 оны 07 дугаар сарын 06...-ний өдрийн  
№ 347 тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Агуулахын барилга	44	1976	ш	1	3,289,481.66	3,289,481.66	0
Нийт					1	3,289,481.66	3,289,481.66	0